# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 21 өдөр Дугаар А/30.

Улаанбаатар хот

## Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2,366,361,926.01 (хоёр тэрбум гурван зуун жаран зургаан сая гурван зуун жаран нэгэн мянга есөн зуун хорин зургаан төгрөг нэг мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансt шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл (О.Мөнхнасан)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1425030076

ᠲᠡᠷ ᠪᠣᠯᠣᠭᠰᠠᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠠᠵᠢᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭ ᠢ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷ ᠢᠶᠠᠨ ᠳᠤ ᠲᠡᠷ ᠰᠠᠶᠢᠨ ᠪᠢᠴᠢᠭ᠌

ᠲᠡᠷ ᠪᠢᠴᠢᠭ ᠲᠡᠷ ᠭᠠᠷᠤᠭᠠᠨ (ᠳ᠂ ᠬᠦᠰᠡᠯᠪᠠᠶᠠᠷ) — ᠪ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠠᠵᠢᠨ ᠄᠄

ᠲᠡᠷ ᠪᠢᠴᠢᠭ ᠢᠶᠡᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠢᠴᠢᠭ ᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠡᠷ ᠪᠢᠴᠢᠭ᠂ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠡᠷ ᠄᠄

ᠬᠠᠮᠲᠤ (ᠬ᠂ ᠪᠠᠲᠤ) — ᠪ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠠᠵᠢᠨ ᠄᠄

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠲᠠᠷᠠᠬᠤ ᠶᠠᠮᠠᠨ ᠤ
ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠠᠵᠢᠨ ᠪ. ᠣᠴᠢᠷᠮᠠ

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 04 дугаар сарын 21 -ны өдрийн А/30 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл

| № | Эд хогшлын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Ашиглалтад авсан он | Нэгж үнэ | Нийт үнэ | Үлдэх өртөг | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Автозам 5.1км | км | 5.1 | 11/7/2022 | 463,992,534.51 | 2,366,361,926.01 | 2,366,361,926.01 | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| **Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн** | | | | | | **2,366,361,926.01** | **2,366,361,926.01** | |